



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/83

Сант сум

Малын хагас жилийн түүвэр судалгаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 "в", 18 дугаар зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 2, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/293 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны малын хагас жилийн түүвэр судалгааг сумын хэмжээнд 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Түүвэр судалгааны ажлын зохион байгуулан явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнх-Эрдэнэ
(Засаг даргын орлогч дарга)

Гишүүд:

Б.Золбаяр
(Хушаат багийн Засаг дарга)
Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

Д.Бямбацэцэг

(Хөдөө аж ахуйн тасгийн Мал зүйч)

Нарийн бичгийн дарга:

З.Оюунсүрэн

(Төрийн сангийн мэргэжилтэн)

3.Баг тус бүр дээр түүвэр судалгааны ажилд явах тоологч, хянагч, жолооч, унааны хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Малын хагас жилийн түүвэр судалгааны ажлыг түүвэрлэгдсэн өрхүүдийг бүрэн хамруулан биечлэн тоолох, бүртгэлжүүлэх ажилд онцгой анхаарал тавьж, судалгаанд ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

43151082

Боловсруулсан: З. Оюунсүрэн
Хянасан: Ч. Ганзориг
Хувь: 2
Огноо: 1999.05.10

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг
даргын 0003 оны 05 дугаар
сарын 29-ны өдрийн А/22 дугаар
захирамжийн хавсралт

Хушаат багт

Тоологч: Д.Бямбацэцэг
(Хөдөө аж ахуйн тасгийн Мал зүйч)

Жолооч: Б.Золбаяр
(Хушаат багийн Засаг дарга)

Шивэгч: Д.Бямбацэцэг
(Хөдөө аж ахуйн тасгийн Мал зүйч)

Ивэн багт

Тоологч: Б.Мөнх-Эрдэнэ
(Засаг даргын орлогч дарга)

Жолооч: Л.Сэлэнгэсайхан
(Ивэн багийн Засаг дарга)

Шивэгч: Л.Сэлэнгэсайхан
(Ивэн багийн Засаг дарга)

Хянагч: З.Оюунсүрэн
(Төрийн сангийн мэргэжилтэн)